



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 15 өдөр

Дугаар А/201

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5.4 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2024 оны төсөвт батлах тухай" 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын зардалд 6,379,380 (зургаан сая гурван зуун далан есөн мянга гурван зуун ная) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.


3. Зардалд шаардагдах 6,379,380 (зургаан сая гурван зуун далан есөн мянга гурван зуун ная) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын зардлын бусад хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/201 дүгээр захирамжийн хавсралт



БОГ МАЛЫН МЯЛЗАНГИЙН ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖИЛД ШААРДЛАГАТАЙ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Ажиллах хоног	Удирдах албан тушаалтан	МЭТасаг	Малын эмч	Санитарч, техникч	Туслах ажилтан баригч	Жолооч	Нийт
1	20	8	1	3	2	2	2	18

ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, БАГАЖ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

№	Зардлын нэр төрөл	Хэмжээ	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Ажлын бээлий	ш	50	3000	150000
2	Маск	ш	50	2000	100000
3	Хурууны лент /бүдүүн/	Хайрцаг	6	5000	30000
4	Хагас автомат	ш	2	100000	200000
5	Бүрэн автомат шприц	ш	2	195000	390000
6	Спирт	ш	4	30000	120000
7	Нэг удагийн ком ХХХувцас	ш	20	18000	360000
6	Шуудан холбоо	ш	7	20000	140000
7	Бусад				350000
8	Туслах ажилтан	Хүн, өдөр	5 хүн 7 хоног	70000	2450000
Бүгд:					4290000

ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

№	Төрөл	Туулах км	Шаардагдах шатахууны хэмжээ /л/	Нэг литрийн үнэ	Нийт мөнгөн дүн
1	1-р баг /машин/	500	100	3590	359000
2	2-р баг /машин/	550	110	3590	394900
3	3-р баг /машин/	150	20	3590	71800
4	4-р баг /машин/	450	60	3590	215400
5	5-р баг /машин/	80	10	3590	35900
6	6-р баг /машин/	800	160	3590	574400
7	Нөөц түлш		12	3590	43080
8	Хяналтаар явах /машин/	550	110	3590	394900
Бүгд		3080	582	3590	2089380

---o0o---